

МОНГОЛЧУУДЫН ӨНГӨНИЙ МЭДРЭМЖ, ТҮҮНИЙ ХАНДЛАГА

М.ЭРДЭНЭ

МУИС-ийн антропологи-археологийн тэнхим

Өнгөний мэдрэмж бол хүн, түүний ойрын төрлийн амьтдад түүхэн хувьслын явцад боловсронгуй болон хөгжсөн чухал шинжүүдийн нэг юм. Хүн дүрст бичний олон сая жилийн түүхэн хувьсал хөгжил гурван хэмжээст орон зайн орчинд явагдсанаар мэдрэхүйн эрхтнүүдийн дотроос харах мэдрэхүй бусад амьтдыг бодвол илүү хөгжин улмаар мэдрэхүй, сэтгэцийн үсрэнгүй хөгжилтэй уялдан харааны эрхтэн төгөлдөржин боловсорч ертөнцийн өнгө ялгах чадварыг олж авсан байна. Ухаант хүн үүссэн цагаас л өнгө тэдний амьдралд чухал үүрэгтэй байж хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн явцад соёлын нэгэн онцгой элемент болон үлджээ.

Өнгө, буюу бүр тодорхой хэлбэл, аль нэг соёлыг тээгчдийн нүдэнд тодорхой өнгө болон тусч байгаа гэрлийн тусгал нь тэдний хувьд гоо зүй, ёс заншил, билэгдлийн цогц утгыг агуулан тодорхой зүйлийг илэрхийлж, тохирох хариу үйлдэл, дэг жаяг, зан үйлийг бий болгодог. Иймээс өнгөний мэдрэмж, түүний хандлага янз бүрийн угсаатан ястнуудад харилцан адилгүй, өөр өөрийн өвөрмөц онцлогтой байх бөгөөд тухайн ард түмний соёл, ёс заншил, эдлэл хэрэглэл, аман болон бичгийн урлагт гүн тусгалаа олсон байдаг.

Монголчуудын өнгөний бэлгэдлийн талаар угсаатны зүй, хэл шинжлэлийн үүднээс судалсан хэд хэдэн бүтээлүүд байдаг ч өнгөний мэдрэмжийн талаар тусгайлан судалсан нь бараг үгүй. Бид энэхүү судалгаагаар Монголчуудын эрхэмлэдэг болон дургүй өнгийг тодорхойлон, өнгөний мэдрэмж, хандлагыг хувь хүний нас, хүйс, мэргэжил, боловсролтой нь холбон авч үзлээ.

СУДАЛГААНЫ ТОЙМ

Өнгө, өнгөний мэдрэмжийн тухай. Эрт үеэс өрнө дорнын эрдэмтэн мэргэд хүн, ертөнцийн амьдралтай өнгө гэрлээр шүтэлцэх учир шалтгааны талаар олон таамаглал дэвшүүлж судалсаар иржээ.

Олон зуун мянган жилийн өмнөөс балар эртний хүмүүс оюун сэтгэлээсээ ундрган гарсан төсөөлөл, дүрслэлээ зургаар илэрхийлэн оршин суугаа агуйнхаа хана туурга, хад чулуун дээр араатан жигүүртэн, ан гөрөө, сүсэг бишрэл, зан бэлгэдлийн тэмдэг зэргийг сийлж, сав шим будгаар зурж эхэлсэн ба хожим нь эрдэс шороог шинжилж бодисын учрыг тайлж эхэлснээр өнгөт нунтаг боловсруулан будаг бэлтгэж, зураасаа олон янзын өнгөөр чимдэг болсон ажээ (Эрдэнэцог, 1999).

Эртний Грек, Ромын гүн ухаантнууд гэрэл, өнгө, харааны уялдаа холбоо ба хүний сэтгэхүйд нөлөөлөх онцлогийн тухай янз бүрийн таамаглал дэвшүүлж "Нүд ба ямар нэг эд зүйлсийн хооронд байх тэр тунгалаг орчин агаар их чухал нөлөөтэй" (Аристотель) хэмээн үзэж байлаа (Цойгнер, 1976).

XVII зууны дунд үед Английн эрдэмтэн И.Ньютон үзэгдэх гэрлийн солонгон задаргааг анх нээсэн нь өнгө судлалын цаашдын хөгжилд суурь болж өгчээ. Үүний дараагаар И.Ньютон, Г.Гельмгольц нар өнгийг физик шинж талаас нь, М.В.Ломоносов, В.Дальтон, Томас Юнг нар психофизик буюу өнгө хүний харах мэдрэхүйд нөлөөлөх талаас (Измайлов ба бусад, 1989) тус тус судлан, Германы гүн ухаантан В.Гёте өнгөний мэдрэмжийн философи буюу өнгө ба хүний сэтгэхүйн хоорондын харилцааны талаар түүхэн-угсаатны зүйн талаас тодорхой жишээ татан өнгө зохирлыг хүн мэдэрч хүлээн авах, илэрхийлэх сэтгэл зүйн үйл явцыг тайлбарлах оролдлого хийсэн байна (Гёте, 1957). Өнгийн сэтгэл зүйн нөлөөлөл, гоо сайхны

илэрхийллийг олон эрдэмтэд үргэлжлүүлэн судалсны дотор Е.С.Пономарева (1984) "хүний өнгийг ойлгох сэтгэл зүйн үндэс нь түүний соёл, ертөнцийг үзэх гоо зүйн төлөвшилт, амьдралын хэв шинж, зан чанар сэтгэхүйтэй нь нягт холбоотой" хэмээн дүгнэжээ.

Хүн төрөлхтний өнгөний мэдрэмжийн түүхэн хөгжлийг ажиглахад хөх ба ногоон өнгийг харьцангуй хожуу хэрэглэж эхэлсэн нь М.Э.Ө III-YI мянганд хамаарах археологийн дурсгалуудаас харагддаг. Г.Гельмгольцын тогтоосноор улаан өнгө нь бусдаас хурдан бөхдөг, ногоон нь арай удаан, харин хөх нь завсрын байдалд байдаг ба өөрөөр хэлбэл улаан өнгийн цочроолт хөх ногооныг бодвол хүчтэй байдагтай үүнийг холбон тайлбарладаг (Новицкий, 1991).

Сэтгэл судлалын талаас нь авч үзвэл ижил чанарын гэрэл ба өнгийг хараагаар хүлээн авах нь янз бүрийн хүмүүст адилгүй байхаас гадна ажиглалтын тодорхой онцлогоос нэг хүнд ч нөлөөлөл нь өөр өөр байна. Өнгө хүний сэтгэлд янз бүрийн нөлөө үзүүлдэг бөгөөд янз бүрийн өнгийг хараад хахир чанга дуу чимээ эсвэл уянгалаг яруу хөгжмийн эгшиг сонссон адил хүний цусны даралт, зүрхний цохилт, амьсгалын тоо өөрчлөгддөгийг сэтгэл судлаачид ажиглажээ (Lurie, 1991).

Өнгөний нэршил. Өнгө зүс түүний таашаал гэгч нь хүн төрөлхтөнд нийтэд нь байдаг гоо сайхны сэтгэлгээний шинж чанар, билиг зөнгөөрөө тааварлан мэдэх чадвар болох тул дэлхийн хүн төрөлхтний өнгө мэдрэмжийн үүсэл, хөгжил үндсэндээ нийтлэг мэт санагдавч бүгд өвөрмөц онцлогтой ажээ. Хүн судлаачдын бүтээлүүдээс харахад байгаль, юмс, үзэгдэл, нийгэм, хүмүүсийн хоорондын харилцааг тодорхойлоход янз бүрийн соёлд өөр өөрийн хэлний онцлог байдаг ба өнгийн хэллэг, нэршил ч үүнээс гадуур байсангүй. Өнгөний бэлгэдлийн учир утга нь тухайн ард түмний зан заншил, газар нутгийн байршил, өв соёлтой нягт уялдаа шүтэлцээтэй байх учир янз бүрийн хэлэн дээр өнгийг ангилах, нэрлэх тогтсон нэр томьёо, тэдгээрийн тоо төрөл хэмжээ харилцан адилгүй байдгийг Berlin, Key нар тогтоожээ (Rosman, Rubel, 1992).

Биологичид, эмч нарын янз бүрийн үндэстэн, угсаатны дунд хийсэн судалгаанаас харахад гэрлийн солонгон задралын өнгүүдийг газар газрын ард түмэн яг адилаар хүлээн авч мэдэрдэггүйгээс өнгөний нэршил соёл бүрт харилцан адилгүй байдаг байна (Соляник, Жуковская, 1988-д ишилснээр).

Зарим хэлэнд өнгийг зөвхөн бараан ба цайвар хэмээн хоёр үндсэн өнгөөр илэрхийлдэг байхад ихэнх хэлүүдэд гурван нэрээр илэрхийлэн улаан, тод (цагаан), бараан (хар) гэсэн нэршил хэрэглэдэг. Гэтэл зарим хэлэнд дөрвөн үндсэн өнгө нэрлэн дээрх өнгүүд дээр нэмж шар, ногоон өнгийг хэлдэг байна. Эдгээр өнгүүд дээр нэмж хөх, бор, ягаан, улбар шар, саарал зэргийг нэрлэдэг хэлүүд ч бас байдаг. Berlin, Key нарын үзсэнээр энэ нь тодорхой өнгүүдийг харж мэдэрч чадахгүй байгаад бус түүнийг хэрхэн хэрэглэж байгаатай холбоотой ажээ.

Манай ард түмэн улаан, шар, хөх өнгийг үндсэн өнгө болгон авч эцэг өнгө гэж нэрлэдгийг Ишбалжир (1704-1788) "Цэцгийн эрих" шастирт өгүүлсэн буй. Бэлгэдэл зүйн үүднээс бол хар, цагаан хоёр нь бүх өнгөний бэлгэдэл утгыг үүсгэх "эцэг, эх хоёр" нь болно. Харин уламжлалт болон дорно дахины өнгөний тухай урлаг, урлалын үзэл ёсоор бол тэн хөх (номин), ногоон шунх (чяс улаан), энгэсэг хүрэн, хонд (улбар улаан), шар, арам хөх долоон өнгийг "эцэг" өнгө, бүх өнгөнөөс бүтдэг цагаан нь "эх" өнгө, цайвар улаан, ягаан, шар, ногоон, хөх зэрэг үүсмэл өнгөнүүд нь "хөвгүүн" өнгө, хар туяат, үнсэн саарал мэтийн муу зүгийн чөтгөр шулмыг зурдаг өнгө нь "зарц" өнгө (Чүлтэм, 1982) гэхчлэн нэрлэгддэг байна. Халхчууд улаан, шар, хөх өнгийг анхдагч, ногоон, хөх ягаан, улбар шар өнгийг хоёрдогч өнгө хэмээн хэлэлцдэгийг угсаатны зүйчид тэмдэглэжээ (Арьяасүрэн, Нямбуу, 1991). Өнгө ялгаж ирсэн уламжлал, нэрлэх

байдлаас үзвэл монголчууд нэг өнгийг 24 янзаар бууруулж, тодотгож нэрлэдэг байжээ.

Монголчуудын өнгөний бэлгэдэл. Аливаа үндэстэн, угсаатанд өөр өөрийн эрхэмлэх, цээрлэх өнгө байдаг ба өнгийг нарийн ялгамжтай хэрэглэх нь үндэстэн, ястан бүрд өөр өөр, тэдний сэтгэл зүй, гоо сайхны тухай үзэл бодолтой уялдаатай, соёлын уламжлалаас хамаараад нэгэн өнгөний тухайд ч өөр өөр бэлгэдэл байж болохыг судлаачид тогтоожээ.

Египетчүүд ногоон өнгийг Нил мөрний өнгө, шар өнгийг элсний өнгө, хөхийг тэнгэрийн өнгө хэмээн дээдлэн шүтдэг.

Солонгосын ард түмний голчлон таашаадаг өнгө нь ягаан, хөх, ногоон, шар, цэнхэр өнгүүд бөгөөд энэ нь тэр орны газар нутгийн байршил, зөөлөн уур амьсгалтай холбоотой байж болно.

Япончууд цагаан, улаан өнгийг ихэд эрхэмлэдэг буюу улаан өнгө нь мандан бадрахын бэлгэдэл болдог учиртай.

Халимагийн ард түмэн улаан, шар өнгийг ихэд эрхэмлэдэг, Хятадууд цагаан өнгийг бэлэвсрэл, гашуудлын өнгө гэж үзэж уй гашуудалд хэрэглэдэг гэх мэт янз бүрийн үндэстний шүтэн биширдэг болон таашаадаг өнгийн талаар олон мэдээнүүд байдаг (Секачева, 1975).

Монгол түмэн балар эрт цаг үеэс өнгө бэлгэдлийг эрхэмлэж ирсэн баялаг түүхтэй улс билээ (Ринчен, 1958). "Монголын нууц товчоо" -нд гардаг өнгийн холбогдолтой зүйлийг судалж үзэхэд улаан, хөх, цагаан, хар гэсэн 4 өнгийг Монголчууд эрт дээр үеэс онцлон үзэж эрхэмлэн дээдэлж ирсэн нь ард түмний үзэл бодол, хүсэл эрмэлзлийг илэрхийлсэн гүн утга санаатай ажээ (Сономцэрэн, 1990). Монголчууд үндсэн өнгөнүүдийн дотроос цагаан, хөх, улаан гурван өнгийг маш дээр үеэс эрхэмд үзэж хүндэтгэн хэрэглэсээр ирсэн бөгөөд хар өнгийг цагааны эсрэг харь өнгө гэж гадуурхдаг тухай Я. Цэвэл (1959) бичжээ.

Өнгөөр бэлгэшээх нь халх ардын зан үйлд багагүй байр эзэлдэг бөгөөд тэдний ертөнцийг үзэх үзэл, эрхлэх аж ахуй зэрэгтэй салшгүй холбоотой байна (БНМАУ-ын угсаатны зүй, 1987). XIX-XX зууны зааг үеийн халх ардын бэлгэдлийн уламжлалаас үзэхэд тэд үндсэн өнгөнүүдийн дотроос цагаан, хөх, улаан, шар, ногоон, хар өнгийг илүү эрхэмлэн бэлгэшээж иржээ. Оросын монголч эрдэмтэн И.П.Жуковская (1988) Монголчуудыг өнгөний хурц мэдрэмжтэй, өнгө бүр бэлгэдлийн өргөн утгыг агуулж байдаг гээд үүнээс хар, цагаан өнгө Монголын соёлд онцлох байрыг эзлэх бөгөөд бусад өнгөнөөс илүү газар орчны нэр, бэлгэдэх ёс заншилд өргөн утгаар хэрэглэгдэх буюу сайн муу гэх адил эсрэг, тэсрэг утгыг агуулдаг гэж тэмдэглэжээ.

Үнэхээр байгаль, нийгэм, хүмүүний оюун санааны ертөнцөд өнгөөр тэмдэглэн дохиолж үл болох юм үзэгдэл гэж бараг үгүй бөгөөд өнгөний билэгдэл бол монголын язгуур соёлын салшгүй нэгэн хэсэг гэдгийг доктор С. Дулам Монголын аман зохиол дахь өнгөний бэлгэдлийн цогцолборуудыг судлан тогтоожээ. Өнгө, угсаатнуудын ялгац тэмдэг болохоос гадна нэгэн угсаатныг ч дотор нь шашин шүтлэг, соёл иргэншлийн байдлаар нь ангилж, нийгмийн язгуур давхаргын ялгааг ч харуулах шинж тэмдэг бас болдог байна (С.Дулам, 2000).

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДХҮҮН, АРГА, АРГА ЗҮЙ

Судалгааг 2000-2001 онд Улаанбаатар хотын хүн амын дунд 2 үе шаттайгаар явууллаа. Судалгаанд нийт 412 хүн хамрагдсанаас 211 эрэгтэй, 201 эмэгтэй хүн оролцжээ. Эдгээрийг насаар нь ангилж үзвэл:

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн нас

Насны бүлэг	Давтамж
16-25	124
26-35	96
36-45	72
46-55	40
56- аас дээш	80
Нийт	412

1-р шатны судалгаанд оролцсон хүмүүсийг яс үндсээр нь авч үзвэл халх 186, буриад 8, дөрвөд 7, урианхай 2, казак 2, торгууд 1, өөлд 1, баяд 1, дарьганга 1, мянгад 1 байв. Судалгаанд оролцсон хүмүүсийн боловсрол, мэргэжлийн байдлыг 2, 3 дугаар хүснэгтүүдээр харууллаа. Судалгаанд хамрагдсан хүний тоо нь хүн амын зохих хэсгийг төлөөлж чадах түүвэр болсон гэж үзэж байна.

Хүснэгт 2. Судалгаанд оролцсон хүмүүсийн боловсролын түвшин

Боловсрол	Эрэгтэй	Хувь	Эмэгтэй	Хувь	Нийт
Дээд	24	11,4%	40	19%	64
Дунд	77	36,7%	64	30,5%	141
Бага	2	1%	2	1%	4
Боловсролгүй	0	0%	1	0,5%	1
Нийт дүн	103	49%	107	51%	210

Хүснэгт 3. Судалгаанд оролцсон хүмүүсийн мэргэжил

Мэргэжил	Давтамж	Хувь
Багш	52	24,8
Инженер техникийн ажилтан	24	11,4
Эмнэлгийн ажилтан	8	3,8
Эдийн засагч	9	4,3
Хуульч	2	1,0
Цагдаа	1	0,5
Нарийн бичгийн дарга	2	1,0
Геологич	1	0,5
Барилгын ажилчин	6	2,9
Ахуй үйлчилгээний ажилтан	3	1,4
Худалдааны ажилтан	3	1,4
Оёдолчин	7	3,3
Тогооч	3	1,4
Оюутан	34	16,2
Мэргэжилтэй нийт	155	73,8
Мэргэжилгүй нийт	55	26,2
Нийт дүн	210	100,0

Судалгааг санамсаргүй түүврийн аргаар 2 шаттайгаар явууллаа. 1-р шатанд хагас төлөвлөсөн ярилцлагын хэлбэрээр хүмүүсийн эрхэмлэдэг өнгүүдийг тодорхойлсны үндсэн дээр 2-р шатны асуулгыг боловсруулан төлөвлөсөн ярилцлагын хэлбэрээр явуулсан.

Судалгаанд оролцсон хүмүүсийн хариултыг нас, хүйс, яс үндэс, боловсрол, мэргэжил болон бусад асуултуудын дагуу ангилан чанарын шинж тэмдгийн судалгааны аргыг хэрэглэн боловсруулав. Үүнд: Шинж тэмдгүүдийн давтамжийг абсолют утгаар болон хувиар тооцоолон гаргаж, судалгаанд хамрагдагчдын нас, хүйс, яс үндэс, боловсрол, мэргэжлийн байдал болон эрхэмлэдэг өнгө, хувцас, гэр, амьдралаа төсөөлөх өнгө, өнгөний гэрэлтэлт, нягтшилтын хоорондын хамаарлыг X^2 , F-критерийн тусламжтайгаар харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ХЭЛЦЭМЖ

Судалгааны дүнгээс харахад дийлэнх оролцогчид цэнхэр ба хөх (29,5 %), цагаан (22.4 %), хар (11.9 %) өнгийг эрхэмлэдэг хэмээн хамгийн их давтамжтайгаар сонгож хариулсан байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Монголчуудын эрхэмлэдэг өнгө

	Эрхэмлэдэг өнгө	Давтамж	Хувь
1.	цэнхэр ба хөх	62	29,5
2.	цагаан	47	22,4
3.	хар	25	11,9
4.	улаан	11	5,2
5.	ногоон	10	4,8
6.	цагаан цэнхэр	9	4,3
7.	ягаан	7	3,3
8.	саарал	4	1,9
9.	хар хөх	4	1,9
10.	хүрэн	4	1,9
11.	улаан хүрэн	3	1,9
12.	шаргал	2	1,0
13.	хар саарал	2	1,0
14.	бор	2	1,0
15.	хар ногоон	1	0,5
16.	цайвар ногоон	1	0,5
17.	бор хүрэн	1	0,5
18.	завсрын өнгө	5	2,4
19.	цайвар өнгө	5	2,4
20.	бараан өнгө	3	1,9
21.	тод өнгө	2	1,0
	Нийт	210	100%

“Цэнхэр” ба “Хөх” өнгийг нийт 62 хүн сонгосноос 30 хүн “цэлмэг хөх тэнгэрийн өнгө” гэж тайлбарласан ба мөн хөх Монгол, цэнхэр хадаг, тайван уужим, хүний

нүдэнд дулаахан харагддаг, тайвшруулдаг гэсэн хариултуудыг өгч байлаа. “Цагаан” өнгөний тухайд “эрхэм нандин өнгө, энх тайвны, ариун цагааны өнгө, амьдралын сайн сайхны бэлгэдэл, эхийн сүүний өнгө, цайлган цагаан, гэрэл гэгээтэй, сэтгэл санааг өөдрөг байлгадаг” гэх зэргээр хариулжээ. Дээрх хоёр өнгөний хувьд Монголчууд мөнх хөх тэнгэр, ариун цагаан, сайн сайхныг бэлэгдэн, уламжлан эрхэмлэж ирсэн өнгө бөгөөд энэхүү уламжлал өнөөг хүртэл хэвээр хадгалагдаж байгаа нь харагдлаа.

Харин монголын аман зохиол, уламжлалт ёс заншилд “муу үйлийн өнгө” (Дулам, 2000) хэмээн нэрлэгдэж аливаа муу бүхнийг бэлэгдэн илэрхийлж байсан хар өнгө өнөөдөр бидний амьдралд түлхүү хэрэглэгдэх болсон нь сонирхол татаж байна. “Хар” өнгийг сонгосон хүмүүс “эрхэмлэдэг, таалагддаг, зохимжтой, нийтлэг өнгө учраас” гэх мэт, нөгөө талаар гоо зүйн үүднээс гадаад төрх байдал, бие галбиртай холбогдуулан “нарийхан харагдуулдаг”, ахуй талаас нь “амархан хиртдэггүй” гэх зэргээр тайлбарласан нь өнөө үед хүрээлэн буй орчин, нийгмийн хөгжлөө дагаад энэ өнгө монголчуудын амьдралд тодорхой байр эзлэх болсныг харуулж байна. Үйлдвэржилт, хотжилт эрчимтэй явагдаж байгаатай уялдан өрнөдийн суурьшмал ард түмний соёл манайд нэвтэрч баяр ёслолын болон албан ёсны арга хэмжээний үед хар өнгийн хувцас өмсөх, албан хаагчид голдуу хар, хар хөх, саарал өнгийн хувцас хэрэглэх зэрэг шинэ зан үйл бий болж, нөгөөтэйгүүр улс орны эдийн засгийн байдал, хүн амын амьжиргааны түвшин хувь хүний өнгөний сонголтонд нөлөөлөн өнгөний талаарх монголчуудын уламжлалт ойлголт, хандлаганд гарч байгаа хувьсал, өөрчлөлт болж байна.

Судалгаанд оролцогчдын дунд “шар” өнгөнд дуртай гэсэн хариулт байсангүй. Ер нь монголын уламжлалт ёс заншилд улаан шар, шар өнгийн эд бөсөөр дээл хувцас хийхгүй байсан нь ламын шашин шар өнгийг ихэнх ёслол бэлгэдэлдээ өөрийн өнгө болгон авч дэлгэрүүлсэн, санваартны өмсгөл хувцас улаан шар өнгөтэй байсантай холбоотой ажээ (Викторова, 1980). Бидний асуулгаас хар ногоон, цайвар ногоон өнгөнд хүмүүс дуртай биш байдаг хандлага ажиглагдлаа.

Эрхэмлэдэг дуртай өнгийг нас, хүйс, яс үндэс, мэргэжил, боловсролоор нь ангилан, хувцас, гэрийн тавилгын өнгө сонголт, амьдралын төсөөлөлтэй нь харьцуулж, хоорондын хамаарал, зүй тогтол байгаа эсэхийг ажиглалаа. Судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг насаар нь ялган авч үзэхэд залуучууд цэнхэр (8.6%), дунд насныхан цагаан (4.8%), ахмад настнууд цэнхэр (5.2%), цагаан (5.2%) өнгийг сонгосон нь эдгээр өнгө аль ч насны монголчуудын хувьд эрхэмлэдэг өнгө болохыг давхар баталж байна.

Өнгөний мэдрэмжийн хүйсийн хамаарлыг авч үзэхэд эрэгтэйчүүдийн хувьд дуртай өнгө нь цэнхэр (22.3%), цагаан (19.4%), хар (13.67%) байхад эмэгтэйчүүд цагаан (25.2%), цэнхэр (21.5%), хар (10.3%) гэсэн дарааллаар өнгийг сонгосон байна (Хүснэгт 5).

Судалгааны 2-р шатны дүнгээр монголчууд цагаан, цэнхэр өнгийг илүүтэй эрхэмлэдэг нь батлагдсан бөгөөд хар өнгийг зарим хүн дуртай гэж бас нэрлэсэн байна (Хүснэгт 6).

Өнгөний мэдрэмж нас ахихад өөрчлөгдөх онцлогтой нь харагдав. Тухайлбал, эрэгтэй хүмүүсийн хамгийн дуртай өнгө нь насны бүлэг бүрт харилцан адилгүй, ялангуяа ахмад насныхан хүрэн, бор гэсэн өнгийг дурдаж байв (Хүснэгт 7; 8). Хамгийн дуртай өнгийг нас болон хүйсээр ангилж үзэхэд 16-25 насны эмэгтэйчүүд (9.6 %) цэнхэр өнгөнд, 26-35 насных (13.8 %) цагаан өнгөнд, 26-45 насны эрэгтэйчүүд хар өнгийг, 46-55 насныхан хөх, хүрэн өнгийг дуртай гэж нэрлэсэн байна.

Өнгө сонголтын статистик магадлалыг χ^2 -критерийн тусламжтай тооцоолоход эрэгтэйчүүдийн өнгө сонголтын тархалт бодит магадлалгүй, эмэгтэйчүүдийнх 99,9%-ийн магадлалтай гарч байв.

Хүснэгт 5. Дуртай өнгө -- Хүйсний хамаарал

№	Дуртай өнгө	Хүйс		Эрэгтэй		эмэгтэй		Нийт дүн
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	
1	цэнхэр	23	22,3	23	21,5			46
2	цагаан	20	19,4	27	25,2			47
3	хар	14	13,6	11	10,3			25
4	хөх	12	11,7	4	3,7			16
5	улаан	9	8,7	2	1,9			11
6	ногоон	7	6,8	3	2,8			10
7	бараан	2	1,9	1	9			3
8	саарал	2	1,9	2	1,9			4
9	улаан хүрэн	2	1,9	1	9			3
10	хүрэн	2	1,9	2	1,9			4
11	хар ногоон	2	1,0					2
12	цагаан цэнхэр	2	1,9	7	6,5			9
13	бор хүрэн	1	1,0					1
14	хар ногоон	1	1,0					1
15	цайвар	1	1,0	4	3,7			5
16	цайвар ногоон	1	1,0					1
17	шаргал	1	1,0	1	9			2
18	ягаан	1	1,0	6	5,6			7
19	бор			2	1,9			2
20	завсар			5	4,7			5
21	тод			2	1,9			2
22	хархөх			4	3,7			4
Нийт		103	100	107	100			210

Хүснэгт 6. Монголчуудын хамгийн дуртай ба хамгийн дургүй өнгө

Хамгийн дуртай өнгө			Хамгийн дургүй өнгө		
Өнгө	Тоо	Хувь	Өнгө	Тоо	Хувь
Цагаан	48	23,8	Шар	36	17,8
Цэнхэр	41	20,3	Саарал	31	15,3
Хар	26	12,9	Улаан	31	15,3
Саарал	24	11,9	Ягаан	21	10,4
Хөх	23	11,4	Ногоон	20	9,9

Улаан	11	5,4	Цагаан	19	9,4
Хүрэн	11	5,4	Хар	18	8,9
Ногоон	7	3,5	Хүрэн	12	5,9
Бор	6	3,0	Бор	8	4,0
Шар	4	2,0	Хөх	3	1,5
Ягаан	2	1,0	Цэнхэр	3	1,5


Хүснэгт 7. Эрэгтэйчүүдийн хамгийн дуртай өнгө

	Нас					Дүн
	16-25	26-35	36-45	46-55	56 - <	
цагаан	5 (4.6%)	7 (6.5%)	3 (2.8%)	1 (0.9%)	3 (2.8%)	19 (17.6%)
цэнхэр	6 (5.6%)	8 (7.4%)	1 (0.9%)	1 (0.9%)	4 (3.7%)	20 (18.5%)
саарал	1 (0.9%)	3 (2.8%)	3 (2.8%)	1 (0.9%)	1 (0.9%)	9 (8.3%)
хүрэн	1 (0.9%)	3 (2.8%)			5 (4.6%)	9 (8.3%)
хөх	6 (5.6%)	1 (0.9%)	2 (1.9%)	4 (3.7%)	1 (0.9%)	14 (13.0%)
ногоон	2 (1.9%)	1 (0.9%)	1 (0.9%)			4 (3.7%)
улаан	2 (1.9%)	2 (1.9%)	2 (1.9%)		2 (1.9%)	8 (7.4%)
Шар	2 (1.9%)					2 (1.9%)
Хар	4 (3.7%)	9 (8.3%)	6 (5.6%)		1 (0.9%)	20 (18.5%)
Бор		1 (0.9%)	1 (0.9%)		1 (0.9%)	3 (2.8%)
Нийт	29 (26.9%)	35 (32.4%)	19 (17.6%)	7 (6.5%)	18 (16.7%)	108 (100%)


Хүснэгт 8. Эмэгтэйчүүдийн хамгийн дуртай өнгө

Өнгө	Нас					Дүн
	16-25	26-35	36-45	46-55	56 - <	
Цагаан	6 (6.4%)	13 (13.8%)	5 (5.3%)	4 (4.3%)	1 (1.1%)	29 (30.9%)
Цэнхэр	9 (9.6%)	6 (6.4%)	2 (2.1%)	1 (1.1%)	3 (3.2%)	21 (22.3%)
Саарал	1 (1.1%)	5 (5.3%)	3 (3.2%)	6 (6.4%)		15 (16.0%)
хүрэн					1 (1.1%)	1 (1.1%)
хөх	3 (3.2%)		3 (3.2%)		3 (3.2%)	9 (9.6%)
Ногоон		2 (2.1%)			1 (1.1%)	3 (3.2%)
Улаан		1 (1.1%)	1 (1.1%)	1 (1.1%)		3 (3.2%)
Шар	1 (1.1%)	1 (1.1%)				2 (2.1%)
Хар	3 (3.2%)	1 (1.1%)		2 (2.1%)		6 (6.4%)
Бор	1 (1.1%)	1 (1.1%)		1 (1.1%)		3 (3.2%)
цагаан		1 (1.1%)	1 (1.1%)			2 (2.1%)
Нийт	24 (25.5%)	31 (33.0%)	15 (16.0%)	15 (16.0%)	9 (9.6%)	94 (100%)

Зураг 1. Монголчуудын дуртай, эрхэмлэдэг өнгө



Зураг 2. Монголчуудын дургүй өнгө



Энэ судалгаанд оролцогчид хамгийн дургүй өнгө гэж шар, саарал, улаан, ягаан өнгийг нэрлэсэн байна (Хүснэгт 6, Зураг 1, 2).

Хамгийн дургүй гэж нэрлэсэн өнгүүдийг судалгаанд оролцогсдын нас, хүйстэй холбон авч үзэхэд шар өнгийг эрэгтэйчүүдийн 19,4 %, эмэгтэйчүүдийн 16,0 %, саарал өнгийг 16,7 ба 13,8 % тус тус нэрлэж эрэгтэйчүүд 16,7 ба 13,0 % нь улаан ба саарал өнгийг, эмэгтэйчүүд 14,9 % нь ногоон өнгийг дургүй гэж тодорхойлжээ. Эрэгтэй, эмэгтэйчүүд ялгаагүй шар, саарал өнгөнд дургүй, харин улаан, ногоон, цагаан

өнгөний хувьд хүйсийн ялгаа харагдаж байна. Насны хувьд залуучууд саарал, улаан, цагаан, ягаан, ногоон өнгөнд, ахмадууд шар өнгөнд дургүй байна (Хүснэгт 9, 10). Дургүй гэж сонгосон өнгөний тархалт эрэгтэй, эмэгтэй аль алинд нь бодит магадлалгүй гарлаа ($p>0.05$).

Хүснэгт 9. Эрэгтэйчүүдийн хамгийн дургүй өнгө

Өнгө	Нас					Нийт
	16-25	26-35	36-45	46-55	56-аас дээш	
Шар	3 (2.8%)	6 (5.6%)	3 (2.8%)	3 (2.8%)	6 (5.6%)	21 (19.4%)
улаан	3 (2.8%)	7 (6.5%)	5 (4.6%)	2 (1.9%)	1 (0.9%)	18 (16.7%)
саарал	6 (5.6%)	3 (2.8%)	4 (3.7%)	1 (0.9%)	4 (3.7%)	18 (16.7%)
ягаан	2 (1.9%)	3 (2.8%)	6 (5.6%)		2 (1.9%)	18 (16.7%)
цагаан	6 (5.6%)	7 (6.5%)			1 (0.9%)	14 (13.0%)
Хар	3 (2.8%)	2 (1.9%)			4 (3.7%)	9 (8.3%)
хүрэн	1 (0.9%)	5 (4.6%)				6 (5.6%)
ногоон	3 (2.8%)	2 (1.9%)		1 (0.9%)		6 (5.6%)
Бор	2 (1.9%)					2 (1.9%)
цэнхэр			1 (0.9%)			1 (0.9%)
Нийт	29(26.9%)	35 (32.4%)	19 (17.6%)	7 (6.5%)	18 (16.7%)	108 (100%)

Хүснэгт 10. Эмэгтэйчүүдийн хамгийн дургүй өнгө

Өнгө	Нас					Нийт
	16-25	26-35	36-45	46-55	56 - <	
Шар	3 (3,2%)	5 (5,3%)	2 (2,1%)	4 (4,3%)	1 (1,1%)	15 (16,0%)
Ногоон	3 (3,2%)	8 (8,5%)	2 (2,1%)	1 (1,1%)		14 (14,9%)
Улаан	3 (3,2%)	4 (4,3%)	3 (3,2%)	1 (1,1%)	2 (2,1%)	13 (13,8%)
Саарал	3 (3,2%)	1 (1,1%)	4 (4,3%)	2 (2,1%)	3 (3,2%)	13 (13,8%)
Хар		5 (5,3%)	2 (2,1%)	2 (2,1%)	1 (1,1%)	9 (9,6%)
Ягаан	5 (5,3%)	1 (1,1%)			2 (2,1%)	8 (8,5%)
Бор	3 (3,2%)	2 (2,1%)	1 (1,1%)			6 (6,4%)
Хүрэн	3 (3,2%)	2 (2,1%)		1 (1,1%)		6 (6,4%)
Цагаан	1 (1,1%)		2 (2,1%)	2 (2,1%)		5 (5,3%)
Хөх		3 (3,2%)				3 (3,2%)
Цэнхэр				2 (2,1%)		2 (2,1%)
Нийт	24 (25,5%)	31 (33,0%)	15 (16,0%)	15 (16,0%)	9 (9,6%)	94 (100%)

Тодорхой өнгийг эрхэмлэх болон үл таашаах мэдрэмжээс гадна аливаа өнгөний тод, бүдэг байдлыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс харилцан адилгүй хүлээж авдаг ба эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол тод, цайвар өнгөнд илүү дуртай байдаг нь харагдлаа. Нийт судалгаанд хамрагдсан хүмүүсээс эрэгтэйчүүдийн 63,0% нь бүдэг, 54,6% нь бараан гэсэн сонголтыг хийсэн байхад эмэгтэйчүүд 53,2% нь тод, 68,1% нь цайвар өнгөнд дуртай гэжээ (Хүснэгт 11, 12). Эмэгтэйчүүд ерөнхийдөө наснаас хамааралгүй бараан, бүдэг өнгөнд дургүй байдгийг судалгааны дүн харуулж байна. Статистикийн хувьд тод, бүдгийн сонголт эрэгтэй, эмэгтэйчүүдэд 95,0%-ийн магадлалтай, бараан, цайвар сонголт эмэгтэйчүүдэд бодит магадлалтай, эрэгтэйчүүдэд бодит магадлалгүй байв.

Хүснэгт 11. Өнгөний тод, бүдгийн сонголт (нас, хүйсээр)

Хүйс		Нас					Нийт
		16-25	26-35	36-45	46-55	56 - <	
Эрэгтэй	Тод	17 (15,7%)	13 (12,0%)	4 (3,7%)	2 (1,9%)	4 (3,7%)	40 (37,0%)
	Бүдэг	12 (11,1%)	22 (20,4%)	15 (13,9%)	5 (4,6%)	14 (13,0%)	68 (63,0%)
Эмэгтэй	Тод	13 (13,8%)	23 (24,5%)	7 (7,4%)	3 (3,2%)	4 (4,3%)	50 (53,2%)
	Бүдэг	11 (11,7%)	8 (8,5%)	8 (8,5)	12 (12,8%)	5 (5,3%)	44 (46,8%)

Хүснэгт 12. Өнгөний гэрэлтэлт (бараан цайвар)-ийн сонголт (нас, хүйсээр)

Хүйс		Нас					Нийт
		16-25	26-35	36-45	46-55	56 - <	
Эрэгтэй	Бараан	13 (12,0%)	17 (15,7%)	12 (11,1%)	4 (3,7%)	13 (12,0%)	59 (54,6%)
	Цайвар	16 (14,8%)	18 (16,7%)	7 (6,5%)	3 (2,8%)	5 (4,6%)	49 (45,4%)
Эмэгтэй	Бараан	7 (7,4%)	6 (6,4%)	4 (4,3%)	10 (10,6%)	3 (3,2%)	30 (31,9%)
	Цайвар	17 (18,1%)	25 (26,6%)	11 (11,7%)	5 (5,3%)	6 (6,4%)	64 (68,1%)

Өнгөний тод бүдэг, бараан цайвар сонголтыг насаар нь ангилж үзвэл 25-аас доош насны эрэгтэйчүүд, 35-аас доош насны эмэгтэйчүүд тод өнгөнд, үүнээс ахмад насны хүмүүс бүдэг өнгийг сонгожээ. Залуу хүмүүсийн эрч хүчтэй хурц дайчин зан чанар, тэдний нас, сэтгэл зүйн онцлог өнгөний сонголтоор илэрч байна. Ер нь залуу зураачийн бүтээл өнгө будгийн ялгарал сайтай, хурц тод өнгө голлодог тухай зураач, урчууд ярьдаг нь бидний судалгааны үр дүнтэй тохирч байна.

Өнгөний мэдрэмж өдөр тутмын амьдралд хэрхэн тусч байгааг бид хүмүүсийн хувцасны өнгө сонголт болон гэрийн дотор зонхилох өнгөний талаар өгсөн

хариултаар тодорхойллоо. Судалгаанд оролцсон хүмүүсээс 17 хүн (8,2%) хар өнгөнд дуртай ба хар өнгийн хувцсыг өмсдөг гэсэн нь дуртай өнгө, хувцасны өнгө тохирсон хамгийн олон хариулт байв. Үүний дараа цагаан өнгийг 7,7% (16 хүн), цэнхэр өнгийг 6,7% (14 хүн) дуртай өнгө хувцасны өнгө хоорондоо тохирч сонгосон байна. Мөн түүнчлэн “Та хувцасны мода-ыг дагаж өнгө сонгодог уу?” гэсэн асуултанд эрэгтэйчүүд дийлэнх нь (60%) “сонгодоггүй” гэж байхад эмэгтэйчүүд тал хувь нь “мода дагаж өнгөө сонгодог” (50%) гэсэн хариулт өгч байгаа нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол хувцасныхаа өнгө сонголтонд илүү анхаарч уян хатан хандлагийг харуулж байна. Гэхдээ үүнд тухайн хүний нас тодорхойлох ач холбогдолтой байна. 16-25 насны залуучууд эрэгтэй, эмэгтэй аль аль нь мода дагаж өнгийг сонгодог, харин 56-аас дээш насны хүмүүс, ахмадууд мода төдийлөн дагадаггүй гэсэн хариулт өгсөн нь дээрхийн баталгаа болно.

“Таны гэрт ямар өнгө голлодог вэ?” гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 17,6% нь цагаан, 13,8% нь улаан, 8,1% нь хүрэн өнгийн тавилга эд хэрэглэл зонхилдог гэж хариулснаас үзэхэд орчин үеийн орон сууцанд амьдардаг хүмүүст гэрийн тавилгаа сонгоход өөрийн дуртай өнгө нь тодорхой нөлөө үзүүлдэггүй байна. Гэрийн тавилганд цагаан өнгө зонхилдог хэдий ч улаан, хүрэн өнгө бас ихээхэн хэрэглэдэг, дуртай өнгөө цагаан, цэнхэр гэж нэрлэсэн хүмүүс ч улаан, хүрэн өнгийн тавилгатай гэж хариулсан нь манай монголчуудын хувьд өнгөний бэлэгдэл ахуйн хэрэглээнд өөр утга агуулж байдгийг харуулж байна. Ер нь монголчууд гэрийн тавилга, эдлэл хэрэглэл, хувцас хунартаа эртнээс тод, хурц өнгүүдийг хэрэглэдэг байсан нь судлаачдын бүтээлүүдэд тэмдэглэгдсэн байдаг (БНМАУ-ын угсаатны зүй, 1987; Викторова, 1980; Жуковская, 1988). Монгол үндэстэн гэрийнхээ унийг улаанаар өнгөлж, ногоон өнгөөр үзүүрийг будсан нь өнгөний эрэмбэнд эсрэг орших харш өнгө болон дулаан хүйтэн өнгүүдийг харилцан шүтэлцүүлж нэгэн цогц болгосон бөгөөд энэ нь арга билиг, эсрэг тэсрэг талуудын нэгдлийг илүүтэй авч үздэг нүүдэлчин ард түмний уламжлалт сэтгэлгээтэй холбоотой байж болно (Эрдэнэцог, 1999).

Хүмүүсийн өнгө сонголтонд тэдний зүс царай, бие галбир, нас, цаг улирлын байдлаас гадна оршин амьдарч буй газар нутаг, байгалийн байдал тодорхой хэмжээгээр нөлөөтэй байдаг ажээ. Судалгаанд оролцсон хүмүүс “хотынхон голдуу цайвар, тод, эрэн мяраан өнгө хэрэглэдэг бол хөдөөнийхөн бараан, цэнхэр, хурц тод биш өнгийг хэрэглэдэг” гэж хариулсан нь амьдрах орчноо дагаад хүмүүсийн өнгөний мэдрэмж харилцан адилгүй байж болохыг харуулж байна. Зарим хүмүүст өнгө сонгох хатуу баримтлал байхгүй, тухайн үеийн байдлаас шалтгаалан ямар ч өнгийн эдийг хэрэглэдэг байхад зарим үед мэнгэ суудал, зурхайн зурлага гоо зүй, хувцасны өнгөний сонголтонд бас нөлөөлөх ч талтай ажээ. Судалгааны дүнгээс харахад яс үндэс, мэргэжил, боловсрол өнгө сонгоход төдийлөн нөлөөлдөггүй, харин монгол үндэстний онцлог, үндэсний үзэл бодол нь дээгүүр тавигддаг байна.

ДҮГНЭЛТ

Монголчуудын эртний уламжлалт өнгөний бэлэгдэл нь асар өргөн утга агуулгатай бөгөөд солонгын долоон өнгө, завсрын болон бараан өнгүүдийг байгалийн үзэгдэл, орчиндоо зохицуулан уусгалт хослолыг хэрэглэн ахуй амьдрал, эдлэл хэрэглэлдээ зохистой хэрэглэж чаддаг байсан нь өнөө хир утга санаагаа алдаагүй байна.

Аливаа ард түмний хувцас эдлэлдээ хэрэглэдэг өнгө нь тэдний амьдардаг орчинтой нь зохистойгоор нийцэх шинжтэйг Гёте анх анхааран тэмдэглэж, өнгөний хандлага ба нас, боловсрол, нийгмийн байгууллын хамаарлыг тэр үеийн герман,

итали, францчуудын жишээн дээр авч үзсэн бөгөөд өөрийн ажиглалт дээр тулгуурлан “Аливаа ард түмэн хүрээлэн буй байгальтайгаа ойр байх тусам тэдний хэрэглэдэг өнгө, өнгөний нийлэмжүүд хурц тод, цэвэр, байгалийн өнгөтэй ойр байна” гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг (Гёте, 1957). Үнэхээр Төв Азийн уудам тал нутагт олон мянган жил иргэншин амьдарсан монгол түмний хувьд цэлмэг тэнгэр, цэнгэг усны өнгө тэнүүн жаргалтай амьдрал, хувиршгүй бат найдвар, энх амгалангийн бэлэгдэл, эхийн сүүний цагаан өнгө ариун дагшин цэвэр тунгалаг, сайн сайхан, нигүүлсэнгүй сэтгэлийн илэрхийлэл болон эрхэмлэгдэж, алаг цэцэгт ногоон талын өнгө нь орон гэр, хувцас эдлэл, гоёл чимэглэлийнх нь өнгө будаг болон бидний үеийг хүртэл уламжлагдан иржээ. Өнгөний мэдрэмж, өнгөний уламжлалт хандлага, ялангуяа, зураачдын бүтээлээс тод харагддаг. Тухайлбал, монголын зураачдын бүтээлийн өнгө зохицол ерөнхийдөө нар шингэсэн, хурц ханасан өнгөтэй байхад Европын нам дор газрын чийглэг уур амьсгалтай, нарны гэрэл харьцангуй бага тусдаг газар нутгийн зураачдын бүтээл саарал өнгийн зохицлыг илүү тусгасан байдаг байна (Эрдэнэцог, 1999).

Орчин үед улс орны эдийн засгийн байдал, нийгмийн хөгжлийг даган монголчуудын соёл, ёс заншил өөрчлөгдөж байгааг монголчуудын хар өнгөний мэдрэмжийн өөрчлөлтөөс харж болох юм. Уламжлалт зан үйлд муу бүхний бэлэгдэл болгон харь өнгө хэмээн гадуурхагддаг байсан “Хар” өнгө өнөөдөр бидний амьдралд тодорхой байр суурь эзлэх болж цагаан, цэнхэр өнгийн дараа орох таашаадаг өнгө болжээ. Хот суурин газрын оршин суугчид, албан хаагчид, мөн түүнчлэн өнгө, гоо зүйн мэдрэмжинд гарч байгаа шинэ хандлагаас харж болно.

Өнгөний мэдрэмж хувь хүний нас, хүйсээс зохих хэмжээгээр хамаарч харин эрхлэх ажил, мэргэжил төдийлөн нөлөөлдөггүй, бүхэл нийтлэгийн хувьд амьдрах орчин, газар зүйн байршил, орон нутгийн онцлог зан үйл, аж ахуйн хэвшил нөлөө үзүүлж болох нь харагдлаа. Түүнээс гадна өнгөний мэдрэмжинд түүний тод, бүдэг, нягтшил чухал бөгөөд хүйсийн мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байна. Эрэгтэйчүүд бараан, бүдэг өнгийг сонирхдог байхад эмэгтэйчүүд тод, цайвар өнгөнд дуртай, энэ нь нас ахихад улам илүү болдог ажээ.

Ном зүй

1. Арьяасүрэн Ч., Нямбуу Х., 1991. Монгол ёс заншлын дунд тайлбар толь, 177-178.
2. БНМАУ-ын угсаатны зүй, 1987. I боть. Халхын угсаатны зүй. Ред. С.Бадамхатан. УБ., УХГ. 432 х.
3. Викторова Л.Л., 1980. Монголы: Происхождение народа и истоки культуры. М., Изд-во “Наука”, 35-38.
4. Дулам С., 2000. Монгол бэлгэдэл зүй. Дэд дэвтэр. Өнгөний бэлгэдэл зүй. Зүг чигийн бэлгэдэл зүй. МУИС-ийн Хэвлэлийн Товчоо. 217 х.
5. Жуковская Н.Л., 1988. Категории и символика традиционной культуры монголов. М., Изд-во “Наука”. 153-169.
6. Измайлов Ч.А., Соколов Е.Н., Черноризов А.М., 1989. Психофизиология цветового зрения, М., Изд-во МГУ, 3-42.
7. Новицкий Е.Ю., 1991. К вопросу о цветовом зрении первобытного человека и полихромности первобытного искусства. Вопросы антропологии, вып. 85, 68-73.
8. Пономарева Е.С. 1984. Цвет в интерьере. Минск.
9. Ринчен Б. 1958. Из нашего культурного наследия (Сборник статей). УБ. 62-65.

10. Секачева А.В. 1975. Рисунок и живопись. М.
11. Сономцэрэн Л., 1990. Монголчуудын өнгөний бэлгэдлийг нууц товчоонд тусгасан нь. An International annual of Mongol Studies. Vol. 1(22).
12. Цойгнер Ф., 1976. Цвет. М.
13. Цэвэл Я., 1959. Монголчуудын эрхэмлэдэг өнгө. УБ.
14. Чүлтэм, 1982
15. Эрдэнэцог Ц., 1999. Уран зургийн өнгө. УБ.
16. Lurie A., 1991. Human Ecology, Spring. 32-34.
17. Rosman A., Rubel P.J., 1992. The tapestry of culture.

Color preference of Mongols, its tendencies

One of the most important signs, and one that makes the greatest and most immediate impact in human communication is colour. Colour harmony, colour preferences and colour symbolism are culturally conditioned, and they vary considerably with both place and time.

Here we present the results of colour preference study of Mongols of different age, ethnicity, education and professional background. The results of the study show that most of Mongols favour white and blue colours, symbolizing purity and kindness, prosperity and happiness. In addition to white and blue, some participants mention black colour as a favourite, which symbolizes evil deed in traditional Mongolian culture. They described black colour as an official, looking slimmer, and very practical.

This suggests us change of Mongols' colour preference, especially in urban areas: besides traditional favourite colours, white and blue, black colour is becoming one of the most used and favourite colour of Mongols under the influence of the social development and western.

Colour preference tends to change with both sex and age of participants, while education and profession are not important factor.